

МОНГОЛ УЛС  
ҮНЭТ ЦААСНЫ ХОРООНЫ  
ТОГТООЛ

1996 оны 04 дугаар  
сарын 04-ны өдөр

Дугаар 29

Улаанбаатар хот

Маягт заавар батлах тухай

Үнэт цаасны тухай Монгол улсын хуулийн 12 дугаар зүйлийн 1. 20 дугаар зүйлийн 3 дахь заалтыг үндэслэн Монгол улсын үнэт цаасны хорооноос ТОГТООХ нь:

1. Үнэт цаасны арилжааны мэдээ маягт №А9-1; Тендер саналын үед тухайн үнэт цаасыг худалдах, худалдан авах захиалгын мэдээ маягт №А9-2; Тендер саналын арилжааны мэдээ маягт №А9-3; Тендер саналын арилжааны мэдээ маягт №А9-4; Аль нэг компанийн үнэт цаасны 5-аас дээш хувийг өмчлөгчдын мэдээ маягт №А9-5 тэдгээрийг гаргах зааврыг хавсралтад дурдснаар баталсугай.

2. Мэдээг үнэн зөв гаргаж долоо хоног бүрийн Бямба гаригт Хорооны албанд ирүүлж байхыг Монголын Хөрөнгийн бирж / С. Энхбаатар /-д үүрэг болгосугай.

3. Мэдээг ирүүлэх, хүлээн авах, албан хэрэгцээнд ашиглах, хадгалахад байнгын хяналт тавьж ажиллахыг ажлын алба / Д. Сэржамц/-нд үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.ЯДАМСҮРЭН

Монгол улсын Үнэт цаасны хорооны  
1996 оны 04 дүгээр сарын 04-ний  
өдрийн 29 дүгээр тогтоолын хавсралт

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖЭЭС ХОРООНД  
БАЙНГА ИРҮҮЛЖ БАЙХ МЭДЭЭНИЙ МАЯГТЫГ  
ГАРГАХ ЗААВАР

1. Үнэт цаас шинээр эсхүл нэмж гаргах, түүнийг арилжаалах, тендер саналаар хувьцааг худалдан авах, аль нэг хувьцаат компанийн нийт гаргасан хувьцааны 5 буюу түүнээс дээш хувийг эзэмших зэрэг үйл ажиллагаатай холбогдон Монголын хөрөнгийн биржээс Үнэт цаасны хороонд байнга гаргаж ирүүлж байх мэдээг баталсан маягтаар үнэн зөв гаргаж тогтоосон хугацаанд Хороонд ирүүлнэ.

НЭГ. Үнэт цаасны арилжааны мэдээ  
Маягт №А9-1

2. Бүртгүүлэх зөвшөөрөл олгосон үнэт цаасыг арилжаалж эхэлснээс хойш Монголын Хөрөнгийн бирж “ Үнэт цаасны арилжааны мэдээ”-г №А9-1 маягтаар үнэн зөв гаргаж, тогтоосон хугацаанд хороонд ирүүлж байна.

3. Мэдээний эхний хэсэгт үнэт цаас гаргагчийн нэр, үнэт цаасны нэрлэсэн үнэ, тоо ширхэг, үнийн нийт дүн, мэдээг гаргаж ирүүлсэн огноо, үнэт цаасыг бүртгүүлэх зөвшөөрөл олгосон огноо, шийдвэрийн дугаар, товч утга, Хөрөнгийн биржид бүртгэн арилжаалж эхэлсэн огноо, бүртгэлийн дугаар байна.

4. Хүснэгтийн 1,2,3 дахь баганад арилжаанд орсон огноо, арилжаалсан үнэт цаасны тоо ширхэг, үнийн дүнг гаргаж бичнэ.

5. Тухайн өдрийн арилжааны үнэ ханшийг нээлтийн, дээд, дунд,доод, хаалтын гэсэн үзүүлэлтээр 4-8 дахь баганад харуулна.

6. Арилжаа явагдсан өдөр худалдсан үнэт цаасны тоо ширхэгийг нийт гаргасан үнэт цаасны тоо ширхэгт харьцуулан хувь гаргаж, 9 дэх баганд бичнэ.

7. Маягт №А9-1-ийг МХБ-ийн арилжаа мэдээлэлийн албанаас гарган албаны захирал гарын үсэг зурж ирүүлнэ. Мэдээг хүлээн авсан Хорооны мэргэжилтэн гарын үсэг зурж, огноог тэмдэглэн хүлээн авна.

8. Үнэт цаасны арилжааны мэдээг арилжаа эхэлснээс хойш 7 хоног бүрийн Бямба гаригт өсөн нэтсэн дүнгээр гаргаж Хороонд ирүүлнэ.

9. Үнэт цаасны арилжааны мэдээ нь тухайн үнэт цаасны хувьд мэдээ гаргасан 7 хоногоос эхлэн 01 гэсэн дугаараар гаргах бөгөөд арилжаалж дууссан 7 хоногийн мэдээний дугаар нь сүүлчийнх байна.

10. Тухайн үнэт цаасыг арилжаалж дууссаны дараа арилжааны нэгдсэн мэдээг гаргаж өгнө. Нэгдсэн мэдээ нь өдөр бүрээр байна.

ХОЁР. Тендер саналын үед тухайн үнэт цаасыг  
худалдах, худалдан авах захиалгын мэдээ  
Маягт №А9-2

11. Аль нэг компанийн үнэт цаасыг худалдан авахаар тендер санал зарлахыг тухайн этгээдэд Хорооноос зөвшөөрсөн шийдвэр гарснаас хойш ажлын 1 хоногт багтаан ажлын албанаас энэ маягтыг холбогдох үзүүлэлтийг нөхөн биржийн Арилжаа мэдээлэлийн албанд хүргүүлнэ. Уг алба нь маягтыг брокерийн пүүсийн дилерүүдэд Даваа гариг бүр тарааж өгөх бөгөөд Баасан гаригийн арилжаа дууссаны дараа мэдээг гаргуулж авна.

12. Арилжаа мэдээлэлийн алба тендер санал хүчинтэй байх хугацааны туршид мэдээг 7 хоног бүрээр Хорооны Бүртгэл санхүү хөрөнгө оруулалтын хэлтэст ирүүлнэ.

13. Тендер санал зарласан үнэт цаасыг худалдах бүх захиалгыг захиалагч нэг бүрээр дансны дугаар, худалдах тоо, үнэ зэрэг үзүүлэлтээр гаргаж, 1,2,3 дугаар баганад харуулна.

14. Эдгээр захиалгын дагуу хэлцэл хийсэн огноог 4,5,6,7 дугаар баганад харуулна.

15. Тендер санал зарласан үнэт цаасыг худалдан авахаар тендер санал зарлагчаас бусад харилцагчдын ирүүлсэн захиалгын захиалагч нэг бүрээр дансны дугаар, захиалсан хувьцааны тоо, худалдан авах үнийн санал зэргийг 8,9,10 дугаар баганад харуулна.

16. Эдгээр захиалгын дагуу хэлцэл хийсэн бол 11,12,13,14 дүгээр баганад худалдсан үнэт цаасыг тоо, үнийн дүн, хэлцэл хийсэн огноог харуулна.

17. Аль нэг компанийн үнэт цаасыг худалдан авахаар хэд хэдэн тендер санал зарласан тохиолдолд тендер санал тус бүрээр уг мэдээг гаргах бөгөөд эдгээр мэдээний 4,5,6,7,11,12,13,14 дүгээр баганын үзүүлэлтээс бусад нь адил байна.

В.Тендер саналын гадуурхи арилжааны мэдээ  
Маягт №А9-3

18. Аль нэг компанийн үнэт цаасыг худалдан авахаар тендер санал зарлахыг тухайн тохиолдолд зөвшөөрсөн Хорооны тогтоол гарсны дараа ажлын өдөрт багтаан ажлын албанаас энэ маягтын холбогдох үзүүлэлтийг нөхөн биржийн Арилжаа мэдээлэлийн албанд хүргүүлнэ.

19. Арилжаа мэдээлэлийн албанаас тухайн тендер санал хүчинтэй байх хугацааны туршид 7 хоног бүр Хорооны бүртгэл санхүү хөрөнгө оруулалтын хэлтэст мэдээг гарган нэгтгэж ирүүлж байна.

20. Нэг компанийн үнэт цаасыг худалдан авахаар хэд хэдэн тендер санал зэрэг зарласан тохиолдолд тендер санал тус бүрээр уг мэдээг гаргана.

21. Тендер санал зарласан үнэт цаасыг тендер санал зарлагч этгээдээс бусад худалдан авсан арилжааг нэг бүрээр 1-6,9 дүгээр баганад харуулна.

22. Худалдах, худалдан авах захиалгын үлдэгдлийг 3 үнийн төвшингөөр 7,8 дугаар баганад харуулна.

ДӨРӨВ. Тендер саналын арилжааны мэдээ  
Маягт №А9-4

23. Хорооноос зөвшөөрсөн тендер саналын хүчинтэй байх хугацаа дууссан үед тендер

саналын арилжаа явагдаж, төлбөр тооцоо хийснээс хойш ажлын 3 хоногт багтааж биржийн Арилжаа мэдээлэлийн албанаас уг мэдээг гаргаж Хорооны Бүртгэл санхүү хөрөнгө оруулалтын хэлтэст ирүүлнэ.

24. Тендер санал зарлагч тухайн үнэт цаасыг худалдан авсан хэлцэл нэг бүрээр, брокерийн пүүс бүрээр хэлцэл хийсэн дэс дараалалаар мэдээг гаргана.

25. Тендер саналын дагуу арилжаалсан хувьцааны нийт тоо, нийт дүн арилжааны дундаж ханш зэрэг үзүүлэлтийг 3,4,5,6 дугаар баганад гаргаж харуулна.

ТАВ. Аль нэг компанийн үнэт цаасны 5-аас  
дээш хувийг өмчлөгчдийн мэдээ  
Маягт №А9-5

26. Аль компанийн нийт гаргасан хувьцааны тав буюу түүнээс дээш хувийг шууд буюу шууд бусаар өмчилсөн этгээдийн тухайн мэдээг Монголын Хөрөнгийн биржийн Төлбөр тооцоо, хадгаламжийн алба Маягт №А9-5 –аар гаргаж, тогтоосон хугацаанд Хорооны Бүртгэл санхүү хөрөнгө оруулалтын хэлтэст ирүүлнэ.

27. Мэдээнд үнэт цаасны нэр, эзэмшигчийн дансны дугаар, овог нэр, худалдан авч өмчилсөн үнэт цаасны тоо хувь, өмчлөгчийн хаягийг бичсэн байна.

28. Мэдээг гаргасан МХБ-ийн Төлбөр тооцоо хадгаламжийн албаны дарга гарын үсэг зурж, он, сар, өдөр тавьж, тэмдэг дарсан байна.

Мэдээг хүлээж авсан мэргэжилтэн гарын үсэг зурж он, сар, өдрийг тэмдэглэсэн байна.

Эдгээр мэдээ нь Хорооны 1995 оны 03 дүгээр сарын 23-ны өдрийн 03 дугаар тогтоолоор баталсан “ Нийтэд санал болгож гаргах үнэт цаасыг бүртгүүлэх зөвшөөрөл авах тухай” журам, мөн 04 дүгээр сарын 13-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан “ Тендер санал гаргах, түүнтэй холбогдсон үйл ажиллагааг зохицуулах тухай” журам, 09 дүгээр сарын 07-ны өдрийн “ Үнэт цаас өмчлөгчийн мэдүүлэг өгөх тухай” журмын хэрэгжилтэнд хяналт тавихад чиглэнэ.

ҮНЭТ ЦААСНЫ ХОРОО

Тендер саналын үед тухайн үнэт цаасыг худалдах, худалдан авах захиалгын мэдээ

Хорооны шийдвэр гарсан  
 .....19....оны .....сар..... өдөр  
 Шийдвэрийн дугаар.....

Тендер санал зарлагчийн нэр.....  
 Тендер саналын хүчинтэй байх хугацаа  
 19...оны ..... сарын..... өдрөөс

....сарын.....өдөр хүртэл.....хоног / сар /  
 Тендер саналаар худалдан авах  
 Хувьцааны нэр.....  
 Худалдан авах үнэт цаасны тоо ширхэг.....  
 Худалдан авахаар санал болгосон нэгжийн үнэ.....

Д/Д	Захиалагчийн дансны дугаар	Худалдах					Хэлцэл хийсэн огноо	Авах						
		Тоо	Үнэ	Үүнээс биелсэн захиалга				Захиалагчийн дансны дугаар	Тоо	Үнэ	Үүнээс биелсэн захиалга		Хэлцэл хийсэн огноо	
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14

Мэдээ гаргасан пүүсийн дилер.....  
 Мэдээг хүлээж авсан мэргэжилтэн.....  
 Мэдээг гаргаж ирүүлсэн огноо.....

Тендер саналын гадуурх арилжааны мэдээ

Хорооны шийдвэр гарсан  
 .....19....оны .....сар..... өдөр  
 Шийдвэрийн дугаар.....

Тендер санал зарлагчийн нэр.....  
 Тендер саналын хүчинтэй байх хугацаа  
 19...оны ..... сарын..... өдрөөс

....сарын.....өдөр хүртэл.....хоног / сар /  
 Тендер саналаар худалдан авах  
 Хувьцааны нэр.....  
 Худалдан авах үнэт цаасны тоо ширхэг.....  
 Худалдан авахаар санал болгосон нэгжийн үнэ.....

Д/Д	Хэлцэл хийсэн пүүсийн код		Хэлцлийн				Захиалгын үлдэгдэл		Арилжаа хийсэн огноо
	Авсан	Худалдсан	Дугаар	Үнэ	Тоо	Дүн	Худалдан авах	Худалдах	
	1	2	3	4	5	6	7	8	9

Арилжаа мэдээлэлийн албаны захирал.....  
 Мэдээг хүлээн авсан мэргэжилтэн.....  
 Мэдээг гаргаж ирүүлсэн огноо.....

Тендер саналын арилжааны мэдээ

Хорооны шийдвэр гарсан  
 .....19....оны .....сар..... өдөр  
 Шийдвэрийн дугаар.....

Тендер санал зарлагчийн нэр.....  
 Тендер саналын хүчинтэй байх хугацаа  
 19...оны ..... сарын..... өдрөөс

....сарын.....өдөр хүртэл.....хоног / сар /  
 Тендер саналаар худалдан авах  
 Хувьцааны нэр.....  
 Худалдан авах үнэт цаасны тоо ширхэг.....  
 Худалдан авахаар санал болгосон нэгжийн үнэ.....

Д/Д	Хэлцэл хийсэн пүүсийн код		Хийсэн хэлцлийн тоо	Худалдаж авсан хувьцаа		
	Худалдсан	Худалдаж авсан		Тоо	Үнийн дүн	Дундаж ханш
	1	2	3	4	5	6

Арилжаа мэдээлэлийн албаны захирал.....  
 Мэдээг хүлээн авсан мэргэжилтэн.....  
 Мэдээг гаргаж ирүүлсэн огноо.....

АЛБ НЭГ КОМПАНИЙН ҮНЭТ ЦААС ТАВААС  
ДЭЭШ ХУВИЙГ ӨМЧЛӨГЧДИЙН МЭДЭЭ

--он ---- сар ----өдөр

Д/Д	Үнэт цаасны нэр	Дансны №	Овог нэр	Тоо	Хувь	Хаяг
1.						
2.						
3.						
4.						
5.						
6.						

Мэдээ гаргасан МХБ-ийн ТТХ-ийн  
Албаны дарга...../ /  
Мэдээ хүлээн авсан Үнэт цаасны  
Хорооны мэргэжилтэн ...../ /

-----он-----сар-----өдөр



1996 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн  
29 дүгээр тогтоолын хавсралт

ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭ

Мэдээг гаргаж буй хугацаа:  
----- оны---- дугаар сарын—ны өдрөөс  
----- оны --- дугаар сарын --- ны өдөр

Үнэт цаас гаргагчийн нэр.....

Нэрлэсэн үнэ.....  
Тоо ширхэг .....  
Үнийн нийт үнэ.....

Хорооны шийдвэр гарсан:  
-----он –дугаар сарын - - - өдөр

Шийдвэрийн товч утга.....  
.....

МХБ-д бүртгэж арилжаалж эхэлсэн:  
----- оны ---- дугаар сар ---- өдөр  
бүртгэлийн дугаар .....

	Арилжаанд орсон он, сар, өдөр	Арилжаалагдсан Үнэт цаасны		Ханш					Тухайн өдөр арилжаалсан хувьцааны нийт хувьцаанд эзлэх хувь
		Ширхэг	Үнэ	Нээлтийн	Дээд	Дунд	Доод	Хаалтын	
	1	2	3	4	5	6	7	8	9
1									
2									
3									
4									
5									
	ДҮН								
	ӨССӨН ДҮН								

МХБ-ийн арилжаа  
мэдээллийн албаны дарга.....

Мэдээг хүлээж авсан  
хорооны мэргэжилтэн.....  
----- он---- сар----- өдөр